

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ, УСТГАХ, БУЛШЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага (цаашид “Ерөнхий шаардлага” гэх) нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох зорилгоор хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг эрхлэхэд тавигдах шаардлага болон **үйл ажиллагааны харилцааг зохицуулахад оршино.**

Commented [MOU1]: Тавигдах ерөнхий шаардлага гэх үү

1.2. Энэхүү ерөнхий шаардлага нь Хог хаягдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

1.3. Ерөнхий шаардлага нь Монгол улсын нутаг дэвсгэр дэх энгийн хатуу хог хаягдалтай холбоотой харилцааг зохицуулахад тавигдах ба цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах эрх бүхий иргэн, хуулийн этгээд болон хог хаягдлыг үүсгэгч этгээдэд хамаарна.

Commented [MOU2]: Ерөнхий шаардлага нь харилцааг зохицуулна гэх зөв үү

Commented [MOU3]: Ерөнхий шаардлага харилцааг

1.4. Энгийн хог хаягдал гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.3-т заасныг ойлгоно.

1.5. Хог хаягдлын тухай хуулийн 9.1.3-т заасан журмыг боловсруулахад энэхүү ерөнхий шаардлагыг удирдлага болгоно.

1.6. Хог хаягдал үүсгэгч этгээд анхдагч эх үүсвэр дээр хог хаягдал үүсгэхдээ болон хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага (цаашид эрх бүхий этгээд гэх) нь эрхлэх үйл ажиллагааны явцад дараах зарчмыг баримтална.

1.5.1. Хог хаягдал аль болох үүсгэхгүй байх;

1.5.2. Хог хаягдал эх үүсвэр дээр нь бага үүсгэх боломжийг бүрдүүлэх, эрэлхийлэх;

1.5.3. Хог хаягдал үүсгэхгүй байх шинэ санаа, санаачлага гаргах, нэвтрүүлэх

1.5.4. Хаягдалгүй эсвэл хог хаягдал бага үүсгэх, шинэ арга, техник, технологи нэвтрүүлэх;

1.5.5. **Хог хаягдал ангилан ялгах ажлыг ногоон буюу байгаль орчинд ээлтэй сэтгэлгээгээр хийж, хэрэгжүүлэх**

1.4.6. Олон улсын шилдэг, дэвшилтэт техник, технологи нутагшуулах;

1.4.7. Хог хаягдлын талаарх мэдлэг боловсролоо байнга дээшлүүлэх;

1.4.8. Хүрээлэн буй орчин, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад иргэн, аж ахуйн нэгж өөрийн оролцоог хангах;

ХОЁР. ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Энгийн хог хаягдал ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин ашиглах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд дараах нийтлэг шаардлага тавигдана.

2.1.1. Энгийн хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 14.2-т заасны дагуу сум, дүүргийн засаг даргатай гэрээ байгуулсан, Хог хаягдлын тухай хуулийн 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлсэн бүртгэлийн дугаар бүхий иргэн, аж ахуй нэгж, байгууллага гүйцэтгэнэ.

2.1.2. Энгийн хог хаягдал сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 9.3.2-т заасан зөвшөөрөл бүхий, 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлсэн бүртгэлийн дугаар бүхий аж ахуй нэгж, байгууллага гүйцэтгэнэ.

2.1.3. Энгийн хог хаягдал үүсгэгч болон энэ журмын 2.1.2 болон 2.1.3-т заасан аж ахуй нэгж байгууллага нь Хог хаягдлын тухай хуулийн 8.1.3-д заасан журам болон 8.1.7.д-д заасан маягтын дагуу үүсгэсэн, цуглуулсан, тээвэрлэсэн, дахин боловсруусан, сэргээн ашигласан, устгасан, булшилсан хог хаягдлын мэдээ тайланг Хог хаягдлын тухай хуулийн 11-д зүйлд заасны дагуу тогтмол, заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

2.1.4 Энгийн хог хаягдал дахин ашиглах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч нь Байгаль хамлгаалах тухай хуулийн 7-р зүйлийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэнэ.

2.1.5. Хог хаягдлыг үүсгэгч болон Эрх бүхий этгээд нь энгийн хог хаягдалтай хамт аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлахыг хориглоно.

2.2. Хог хаягдлыг ангилах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.7-д заасныг ойлгох ба ерөнхий шаардлагад дараах үйл ажиллагаа хамаарна:

2.2.1. Иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь үүсгэж буй энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр болон үйл ажиллагааны явцад дахин ашиглагдах, хүнсний хаягдал, үнс болон бусад гэсэн төрлөөр заавал ангилна.

2.2.1.1. Дахин ашиглах боломжтой хог хаягдалд дараах хог хаягдал хамаарна:

- Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савалгаа/
- Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, 0,025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав, гм/
- Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйлс
- Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл/

- Лааз
- Мод, модон эдлэлийн хаягдал
- Хувцас, даавуун эдлэл
- Савхи, резин
- Өвс, мод

2.2.1.2. Хүнсний хог хаягдалд дараах хог хаягдал хамаарна:

- Хоолны үлдэгдэл
- Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл
- Яс
- Хэрэглэсэн хүнсний тос

2.2.1.3. Үнсэнд дараах хаягдал хамаарна:

- Өрхийн
- Халаалтын болон нам даралтын зуух
- Цахилгаан болон дулааны станцын зуух

2.2.1.4. Бусад хог хаягдалд дараах хог хаягдал орно:

- Хэт бохирдсон дахин ашиглах боломжгүй хог хаягдал;
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй мал, амьтны сэг зэм, ургамлын хог хаягдал;
- Барилгын болон тусгаарлах материалаас гарсан дахин ашиглах боломжгүй хог хаягдал;
- Боловсруулсан дахин ашиглах боломжгүй бохир хөрс, шороо, чулуу, элс, хайрга;
- Хаягдал халдваргүйжүүлэх төхөөрөмжөөс гарсан дахин ашиглах боломжгүй хог хаягдал, далан, усан сангийн лав /үйлдвэрийн цэвэрлэх байгууламжаар гарах лаваас бусад/;
- Ахуйн болон үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний дахин ашиглах боломжгүй, аюулгүй хог хаягдал;
- Дахин ашиглах боломжтой хог хаягдлын ангилалд ороогүй бусад зөвшөөрөгдсөн хог хаягдал

2.2.2. Мөн дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч эрх бүхий этгээдийн тавьсан хэрэгцээ шаардлага, тухайн орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлаганд тулгуурласан төрлөөр хог хаягдлыг ангилан ялгаж болно.

2.2.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ангилсан хог хаягдлаа зориулалтын дагуу Эрх бүхий этгээдэд болон дахин ашиглах боломжтой хог хаягдал хүлээн авагчид тушаах үүрэгтэй.

2.2.4. Эрх бүхий этгээд ангилсан хог хаягдал тус бүрийг зориулалтын газар хүргэх ажлыг зохион байгуулна.

2.2.6. Хог хаягдлыг ангилах төрөл, зүйлийг энэхүү Тавигдах ерөнхий шаардлагын 2.1.2-т заасныг үндэслэн орон нутгийн онцлогоос хамаарч тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

2.2.7. Хогийн савны хэмжээ, төрөл, хэлбэр, өнгийг орон нутгийн онцлогоос хамаарч тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоох ба дараах ерөнхий шаардлагыг мөрдөнө.

2.2.7.1. Ангилян ялгах хог хаягдлын төрлөөр хогийн савыг өнгөөр ялгасан, эсвэл ангилах ялгах зориулалтын тэмдэг, тэмдэглээ бүхий байж болно.

2.2.7.2. Айл өрхийн гэрт 5-10, хашаанд 80-120, байгууллагын дотор 10-40, гадна 80-150 литрийн багтаамжтай;

2.2.7.3. Цоорч гэмтээгүй, шингэн нэвчихгүй, угааж цэвэрлэхэд хялбар;

2.2.7.4. Тагтай, хуванцар, метал материалаар хийгдсэн;

2.2.7.5. Салхин доор, гэр байшин, хүнс боловсруулах, хадгалах газар, хүүхдийн тоглоомын талбайгаас 20-30 метрт байрлуулсан;

2.2.7.6. Хогийн сав байршуулах талбайн хөрсийг тэгшлэн, нягтаршуулсан, цементлэсэн, зориулалтын хавтан, дэвсгэр дэвссэн;

2.2.7.7. Тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх зай талбайтай;

2.2.8. Иргэн, аж ахуй нэгж байгууллага нь хог хаягдлын овор хэмжээг багасгах боломжийг бүрдүүлэх, арга хэмжээ авч зохион байгуулна.

2.3. Энгийн хог хаягдлыг цуглуулах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.8-д заасныг ойлгох ба хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас гадна Ерөнхий шаардлагад дараах үйл ажиллагаа хамаарна:

2.3.1. Хог хаягдлын тухай хуулийн 14.2-т заасан гэрээнд хог хаягдал цуглуулах төрөл, хэлбэр, хогийн цэгийн байршил, ажиллах цагийн хуваарь, орчны тохижилт, ариун цэврийн шаардлагын талаар тодорхой тусгасан байна.

2.3.2. Хог хаягдлыг цуглуулахдаа түр цэг байгуулж эсхүл явуулаар цуглуулж болно. Түр цэг байгуулах газрыг сум, хорооны Засаг даргын зөвшөөрлөөр байгуулна.

2.3.3. Хог хаягдал цуглуулах түр цэг нь 2.2.7.5 - 2.2.7.7 -д заасан шаардлагаас гадна дараах ерөнхий шаардлага хангасан байна.

2.3.2.1. орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн талбай, явган хүн, авто машины хөдөлгөөнд саад учруулахааргүй газар байна.

2.3.2.2. Хог хаягдал хийсэх, агаар болон хөрсөнд тархах, шингэх, уусах, үнэр тархахгүй нөхцлийг бүрдүүлсэн байх

2.3.2.3. хог хаягдлын төрөл, ангиллын мэдээллийг ил харагдахуйц байршуулсан байна.

2.3.2.4. Байгаль орчинд сөргөөр үл нөлөөлөх нөхцлөөр буюу чанарын шаардлага хангасан сав, савлагаа, хог хаягдал түр хадгалах байр сав, явуулын хэрэгсэл бүхий орчин байна.

2.3.2. Хог хаягдал цуглуулах иргэн, аж ахуй нэгж, байгууллагын ажилтан нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

2.3.2.1. хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зохих мэдлэгтэй байх

Commented [MOU4]: Хог хаягдлын хуулинд энэ заалт байхгүй болсоо байна. Түр цэгийн талаар хаана ч тусгаагүй байна.

Commented [MOU5]: Түр цэгийн талаар хуулинд тусгаагүй байгаа тул орццлах уу, яах уу

2.3.2.2. хөдөлмөр хамгааллын нэг бүрийн хэрэгсэл хэрэглэх

2.3.3. Хог хаягдлын цуглуулахдаа ангилан ялгасан хог хаягдал тус бүрээр нь цуглуулна.

2.3.4. Зөвшөөрснөөс бусад газар хог хаягдал цуглуулахыг хориглоно.

2.4. Энгийн хог хаягдлыг тээвэрлэхэд Хог хаягдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас гадна Ерөнхий шаардлагад дараах үйл ажиллагаа хамаарна:

2.4.1. Хог хаягдал тээвэрлэх эрх бүхий этгээдийн Хог хаягдлын тухай хуулийн 9.4.2-т заасан гэрээнд дараах зохицуулалтуудыг тусгана.

2.4.1.1. хог тээвэрлэх график, маршрутыг жил, улирал, сараар гаргаж, хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногт багтаан сум, дүүргийн Засаг даргаар батлуулна.

2.4.1.2. дуудлагаар хог хаягдал тээвэрлэх үйл ажиллагааг мөн эрхэлж болох ба энэ талаар гэрээнд тодорхой тусгана.

2.4.2. Хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь Хог хаягдлын тухай хуулийн 14.6, 14.8-д заасан шаардлагаас гадна дараах Ерөнхий шаардлагыг хангасан байна.

2.4.2.1. Орчин үеийн дэвшилтэт технологи бүхий ачиж буулгах механизмтай;

2.4.2.2. Ямар төрлийн хог хаягдал тээвэрлэх зориулттайг заасан тэмдэг, тэмдэглэгээтэй

2.4.2.3. Хог хаягдал үүсгэгчийн ангилсан хог хаягдал тус тугийг тусад ачих зориулалтын битүүмжлэлтэй, хогийг шууд битүүмжлэл (битүүмжлэлтэй гэж хог ачих үед асарч, хийсч, гоожихгүй таг, хучлага бүхий савыг хэлнэ)-тэй ачдаг арга ажиллагаатай;

2.4.2.4. Галын хор, анхан тусламжийн хэрэгсэл, дугуйн ивүүр, суудлын бүс зэрэг аюулгүй ажиллагааны шаардлага хангасан.

2.4.2.5. Хотын өнгө үзэмжид нийцсэн цэвэрхэн, тээврийн хэрэгслийн стандарт шаардлагыг хангасан хэмжээтэй;

2.4.3. Хог хаягдал тээвэрлэх жолооч, ачигч, туслах ажилтан нар нь Хог хаягдлын тухай хуулийн 14.7-д зааснаас гадна дараах шаардлагыг хангана.

2.4.3.1. хөдөлмөр хамгаалалын хэрэгсэл өмсөж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.

2.4.3.2. харилцааны соёлд суралцсан, хог хаягдлын талаарх нийгмийн хариуцлагаа ухамсарласан ажиллах хүчин байна.

2.4.3.3. хог хаягдлын тээврийн хэрэгсэлийн жолооч нь Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийг ягштал дагаж мөрдөн ажиллаж, зохих ангилалын тээврийн хэрэгсэл жолоодох жолооны үнэмлэхтэй байна.

2.4.3.4. Хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгсэлийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаа болон цэвэр цэмцгэр байдалд анхаарч ажиллана.

2.4.4. Хог хаягдал тээвэрлэх үйл ажиллагаа нь Хог хаягдлын тухай хуулийн 14.5, 14.8-д зааснаас гадна дараах шаардлагыг хангаж ажиллана.

2.4.4.1. хог хаягдлын батлагдсан чиглэл, маршрут, хуваарийн дагуу тээвэрлэнэ.

2.4.4.2. ангилан ялгасан хог хаягдал тус бүрээр тээвэрлэлт хийнэ.

2.4.4.3. тээврийн чиглэл, хуваарийг газарзүйн мэдээллийн системийн байршил тогтоох системд оруулна, хяналт, мэдээллийн системийн хүртээмжийг бий болгоно.

2.5. Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.11-д заасныг ойлгох ба хуулийн 16,17 дугаар зүйлд зааснаас гадна Ерөнхий шаардлагад дараах үйл ажиллагаа хамаарна:

2.5.1 Хог хаягдлыг дараах байдлаар ашигласныг сэргээн ашиглах гэж үзнэ.

2.5.1.1. Хог хаягдлыг байгаль орчинд хоргүй технологиор зориулалтын байгууламж, тоног төхөөрөмжид зөвшөөрсөн газарт шатааж, эрчим хүч /цахилгаан, дулаан, халуун ус/ үйлдвэрлэх

2.5.1.2. Байгаль орчинд ээлтэй нөхцөлөөр, зөвшөөрсөн арга, технологиор хог хаягдлыг нэрэх, угаах, ариутгах, цэвэрлэх, сэргээх аргаар боловсруулж, эргүүлэн ашиглах чанарын шаардлага хангасан, эдийн засгийн хувьд ашигтай болгож хог хаягдлыг анхны хэлбэрт оруулах

2.5.2. Төвлөрсөн хогийн цэгт эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр барьж болох ба хог хаягдлыг тээвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт хүргэх боломжгүй алслагдсан газар нутаг, суурин газарт жижиг оврын зуух ашиглан дулаан, халуун ус үйлдвэрлэж хог хаягдлыг сэргээн ашиглаж болно.

2.5.3. Тавигдах шаардлагын 2.4.4-д заасан жижиг оврын зуух нь аймаг, нийслэлийн Засаг даргаас зөвшөөрөл авсан, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хүлээн зөвшөөрөгдсөн, дэвшилтэт технологи бүхий өндөр даралтын, хорт утаа үл гаргах төхөөрөмж байна. Зөвшөөрөл авах асуудлыг Хог хаягдлын тухай хуулийн 9.3.2-д заасан журмаар зохицуулна.

2.5.4. Хог хаягдлын сэргээн ашиглах үйл ажиллагаа нь Хог хаягдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаас гадна дараах ерөнхий шаардлагыг хангаж ажиллана.

2.5.4.1. Сэргээн ашиглах үйл ажиллагааг эрхлэхдээ орчин үеийн дэвшилтэт техник технологи бүхий хүлээн зөвшөөрөгдсөн арга хэрэгслээр боловсруулж, хийнэ.

2.5.4.2. НЭМЭХ

2.5.5. Хог хаягдлын сэргээн ашиглах байгууламж нь Хог хаягдлын тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаас гадна дараах ерөнхий шаардлагыг хангаж ажиллана.

2.5.5.1. НЭМЭХ

2.5.6. Хог хаягдлын сэргээн ашиглах байгууламжийг эзэмшигч нь ажилд орогсдод ажилд орохын өмнө болон жилд нэг удаа тогтмол доорх мэдээлэл

агуулсан сургалт, мэдлэг сэргээх дахин сургалт болон зааварчилгааг өгч байх шаардлагатай.

2.5.6.1. ажилчдын үүрэг хариуцлага

2.5.6.2. нэг бүрийн хамгаалалтын хувцас, хэрэглэл хэрэглэх заавар

2.5.6.3. гал гарах, осол аваар болон байгалийн гамшигт үзэгдэл болох үед авах арга хэмжээ

2.5.6.4. харилцаа холбоо болон дохиоллын системийн ажиллагаа, хэрэглээ

2.5.6.5. байгууламж үйл ажиллагаа, аюулгүй ажиллагааны арга хэмжээ

2.6. Энгийн хог хаягдлыг дахин боловсруулах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.12-д заасныг ойлгох ба хуулийн 16, 17 дугаар зүйлд зааснаас гадна Ерөнхий шаардлагад дараах үйл ажиллагаа хамаарна:

Commented [MOU6]: 2.6 2.7 2.8 үйл ажиллагаа, байгууламж, ажилчидад тавих шаардлага гэх зэргээр төрөлжүүлж цэглэх

2.6.1. Дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй, хоргүй, эдийн засаг, нийгмийн үр ашигтай, боловсруулсан бүтээгдэхүүн нь чанар стандартын шаардлага хангасан, дахин боловсруулахаас өмнөх үеийн шинж байдлаасаа дордоогүй бүтээгдэхүүнийг дахин боловсруулна.

2.6.2. Дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч Эрх бүхий этгээд нь хог хаягдал боловсруулах өөрийн үйлдвэр, байгууламжид шаардлагатай түүхий эд болох хог хаягдлын төрөл, зүйл, сав баглаа бүхий хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлж болох ба ирүүлсэн хэрэгцээ шаардлагыг үндэслэн тухайн орон нутгийн онцлогт тохируулан ангилах хог хаягдлын төрөл, зүйл, сав баглааны тоог аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр нэмж болно.

2.6.4. Дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч Эрх бүхий этгээд түүхий эд болох хог хаягдлыг өөрөө болон хог хаягдал цуглуулах эрх бүхий этгээдээр дамжуулан цуглуулж болно

2.6.7. Дахин боловсруулсан шинэ бүтээгдэхүүнийг борлуулах, үйлдвэрийн үйл ажиллагааг өргөжүүлэх, дахин боловсруулах хог хаягдал нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зэрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга Эрх бүхий этгээдтэй хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлнэ.

2.6.8. Хог хаягдал дахин боловсруулах арга, технологи нь байгаль орчинд ээлтэй, орчин үеийн хүлээн зөвшөөрөгдсөн дэвшилтэт техник технологи байна.

2.6.9. Дахин боловсруулах үйлдвэрээс гарсан шинэ бүтээгдэхүүн нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хүн, мал, амьтан, ургамал, байгаль орчинд аюулгүй хүний хэрэгцээ шаардлагыг хангасан байна.

2.7. Энгийн хог хаягдлыг устгахад Хог хаягдлын тухай хуулийн 4.1.20-д заасныг ойлгох ба хуулийн 16,17 дугаар зүйлд зааснаас гадна Ерөнхий шаардлагад дараах үйл ажиллагаа хамаарна:

2.7.1. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор энгийн хог хаягдлыг устгахад дараах төрлийн үйл ажиллагаа хамаарна.

2.7.1.1. Хог хаягдлын төвлөрсөн цэгт эрх бүхий этгээд зориулалтын тоног төхөөрөмжөөр ландфилл аргаар газарт булшлах;

2.7.1.2. Химийн аргаар зарим төрлийн хог хаягдлыг урвалд оруулж, боловсруулж устгах;

2.7.1.3. Биологийн аргаар байгаль орчинд ээлтэй нөхцлөөр боловсруулж устгах;

2.7.1.4. Том оврын болон бага оврын зууханд байгальд ээлтэй технологиор хог хаягдлыг шатаах;

2.7.1.5. Хог хаягдлыг халдваргүйжүүлж, байгальд хоргүй болгож устгах;

2.7.2. Энгийн хог хаягдлыг савлаж хадгалах аргаар устгахыг хориглоно.

2.7.3. Хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагаа хийгдсэний дараа үлдсэн хог хаягдлыг энэ тавигдах шаардлагын 2.6.1-д заасан аргын аль тохирохыг ашиглан хог хаягдлыг устгана.

2.7.4. Хог хаягдлыг зориулалтын дагуу устгахдаа байгаль орчинд ээлтэй технологиор, дэлхий нийт хүлээн зөвшөөрсөн арга, техник хэрэгслээр устгана

2.7.5. Энэ шаардлагын 2.6.1.1-д заасан аргыг аль болох ашиглахгүй, бусад аргыг ашиглахыг нэн тэргүүнд тавина.

2.8. Энгийн хог хаягдлыг булшлах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.14-д заасныг ойлгох ба хуулийн 16, 17 дугаар зүйлд зааснаас гадна Ерөнхий шаардлагад дараах үйл ажиллагаа хамаарна:

2.8.1. Байгальд 5-10 жилд хоргүйгээр уусч алга болох хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт зөвшөөрөгдсөн ландфилл талбайд зориулалтын тоног төхөөрөмжөөр булшилна.

2.8.2. Байгальд 10-аас дээш жилийн дараа уусах, байгальд хортой нөхцөл үүсгэх хог хаягдлыг булшлахыг хориглоно.

2.8.3. Хог хаягдлыг булшлах ажиллагаа нь дэлхийн эрүүл мэндийн болон байгаль орчны холбогдох байгууллагуудаас гаргасан зөвлөмжийн дагуу байгаль орчинд хоргүй нөхцөлөөр, ландфилл аргаар хийгдэнэ.

2.8.4. Энгийн хог хаягдал булшлах төвлөрсөн цэгт тавигдах шаардлага болон зохицуулах харилцааг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар”-аар зохицуулна.

ГУРАВ. БУСАД ЗҮЙЛ

3.1. Энгийн хог хаягдал ангилал, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд дараах этгээдүүд хяналт тавина.

3.1.1. Иргэн

3.1.2. Төрийн байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагчид

3.1.3. Хувийн хэвшлийн хуулийн этгээд, байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагчид

3.1.4. Хэсгийн ахлагч, орон нутгийн идэвхтэн гишүүд

3.1.5. Цагдаа, олон нийтийн хэв журам сахиулах байгууллага, иргэн, албан тушаалтан

3.1.6. Олон улсын байгууллага

3.1.7. Орон нутгийн төлөөлөгч, бүрэн эрхэт гишүүд

3.1.8. Мэргэжлийн хяналтын байцаагч,

3.1.9. Байгаль орчны байцаагч,

3.1.10. Хог хаягдлын асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан

3.1.11. Байгаль хамгаалагчид

3.2. Энэ тавигдах шаардлагыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэл эрүүгийн шинжтэй бол Эрүүгийн хуулийн, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Хог хаягдлын тухай хууль болон Зөрчлийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.